

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/20.

Арвайхээр сум

ГЭрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл шинээр олгох, сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, 6.1 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 11 дүгээр сарын 03-ний өдрийн а/383 дугаар тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын ажиллах журам”- ын 4.5, 5.1.2, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой ажлыг гүйцэтгэх ажлын албаны ирүүлсэн санал, дүгнэлт, Эрүүл мэнд эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрийг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг шинээр олгох нэр бүхий 3 байгууллага, аж ахуйн нэгжийн нэрийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий 1 аж ахуйн нэгжийн нэрийг хоёрдугаар, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах 1 аж ахуйн нэгжийн нэрийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

622301061

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 05 дугаар сарын 15-ны
өдрийн 116 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ НЭР БҮХИЙ
БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох Хэлбэр/ хугацаа	Эхэлсэн огноо	Хүчинтэй байх хугацаа/ огноо
1	"Чинмэнд" ХХК -ны Чинмэнд эмийн сан (РД: 3550389)	Нийтэд үйлчлэх эмийн сан	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, Рэнчинпэлжээ гудамж, 1-107, Чин мэнд эмнэлгийн байр	Шинээр олгох	2024 оны 05 сарын 15 -ны өдөр	2027 оны 05 сарын 15- ны өдөр хүртэл
2	Өвөрхангай аймаг дахь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (РД: 9047646)	Тусгай эмнэлэг/ анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлнэ/	Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 13 дугаар баг, өөрийн байр	Шинээр олгох	2024 оны 05 сарын 15 - ны өдөр	2027 оны 05 сарын 15- ны өдөр хүртэл
3	Энх Царам ХХК -ны Ганга эмийн сан (РД: 3573087)		Өвөрхангай аймгийн Бат- Өлзий сумын 3 дугаар баг,Өвт, 10-р гудамж 1000 тоот	Шинээр олгох	2024 оны 05 сарын 15 - ны өдөр	2027 оны 05 сарын 15-ны өдөр хүртэл

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 01 дугаар сарын 15-ны
өдрийн 4 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ НЭР БҮХИЙ БАЙГУУЛЛАГА,
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Сунгах хугацаа	Хүчинтэй байх огноо
1	Арвай оюу арвижих ХХК ны "Энэрэл" хувийн хэвшлийн эмийн сан (РД: 3575543)	нийтийн үйлчилгээтэй 2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Нарийнтээл сум, Баянтээг баг	Сунгах	5 жилээр	2028 оны 12 дугаар сарын 25 ны өдөр хүртэл

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын
2024 оны 05 дугаар сарын 15-ны
өдрийн 4 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ НЭР БҮХИЙ
БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР

№	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, регистрийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга
1	“ЭНХ ОРГИЛ ЖАЗ” ХХК -ны ЭНХ ОРГИЛ ЖАЗ” нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сумын 5 дугаар багийн “Дэлгэр” төв	Арвайхээр сумын 5 дугаар багийн “Дэлгэр” төвийг буулгаж, шинэ барилгын ажил хийгдэх шалтгаанаар тус хаягнаас Арвайхээр сумын 3 дугаар багийн “Хос арвижих” төвийн 2-р давхарт түр байршиж, үйлчилгээг явуулах тул хаягийн өөрчлөлт хийх